

“Цэвэр агаар сан” болон агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр гадаад, дотоодын хөрөнгөөр хийгдсэн ажлын үр дүн

Үндэсний аудитын газар

| Гүйцэтгэлийн аудитын газар

АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ


2018 оны 5 дугаар сар

Агуулга

1. Аудитын нэр, код	2
2. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	2
3. Аудитын зорилт	2
3. Үндсэн мэдээлэл	2
4. Аудитын хамрах хүрээ	3
5. Эрсдэлийн үнэлгээ	4
6. Аудитын арга зүй.....	4
7. Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд	4
8. Аудит хийх багийн бүрэлдэхүүн.....	6
9. Аудит хийх хугацаа.....	6
10. Аудитын хөтөлбөр	6
11. Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам	6
12. Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц	7
13. Хавсралт №1 Аудитын эрсдэлийн үнэлгээ	
14. Хавсралт №2 Асуудлын шинжилгээ	
15. Хавсралт №3 Аудитын арга зүй	
16. Хавсралт №4 Аудитын хөтөлбөр	
17. Хавсралт №5 Аудитын үр өгөөж	

БАТЛАВ. МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

/Д.ХҮРЭЛБААТАР/



Аудитын төлөвлөгөө

1. Аудитын нэр, код

“Цэвэр агаар сан” болон 2008-2016 онд агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр гадаад, дотоодын хөрөнгөөр хийгдсэн ажлуудын үр дүн
Код: ГАГ-2018-13-ГА

2. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2018 оны 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/40 дүгээр тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

3. Аудитын зорилт

Аудитаар Цэвэр агаар сан болон 2008-2016 онд агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр гадаад, дотоодын хөрөнгөөр санхүүжүүлсэн ажлуудын хэрэгжилтийн байдлыг шалган холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:

1. Агаарын бохирдлыг бууруулах төрийн бодлогыг оновчтой тодорхойлсон эсэх
2. Агаарын бохирдлыг бууруулах бодлого үр дүнтэй хэрэгжсэн эсэх

3. Үндсэн мэдээлэл

Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр 2008-2016 онд УИХ-аас 26 хууль, 11 тогтоол, Засгийн газраас 24 тогтоол, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс 2 зөвлөмж гаргаж, баталсан бөгөөд энэ хүрээнд салбарын сайдын баталсан тушаал, журам, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны тогтоол, гадаад, дотоодын хөрөнгөөр дээрх онуудад нийт 322 арга хэмжээг хэрэгжүүлж, 690.0 орчим тэрбум төгрөг зарцуулсан байна. Үүнийг эх үүсвэр тус бүрээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

/тэрбум төгрөг/

№	Эх үүсвэр	Хэрэгжүүлсэн хэмжээний тоо	арга	Санхүүжилт /гүйцэтгэлээр/
1	Улсын төсөв	8		59.2
2	Цэвэр агаар сан	271		92.3
3	Гадаадын тусламж зээл,	10		529.2
4	Орон нутгийн төсөв	25		7.2
5	Монгол Улсыг хөгжүүлэх сан	8		2.1
Нийт дүн		322		690.0

Эх үүсвэр: Сангийн яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар



Цэвэр агаар сан нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд оруулсан 2010 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн өөрчлөлтөөр үүсгэн байгуулагдаж байсан бол тус хуульд 2015 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр орсон өөрчлөлтөөр татан буугдсан байна.

Үндэсний аудитын газраас 2013-2018 онд Цэвэр агаар сангийн хөрөнгийн зарцуулалт болон агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр гадаад, дотоодын хөрөнгөөр хийгдсэн ажлуудын хэрэгжилт, үр дүнд санхүүгийн, гүйцэтгэлийн, нийцлийн аудит хийсэн байна. Үүнд:

№	Аудит хийсэн он	Аудитын нэр	Хамрах хүрээ	Төрөлжсөн аудитын газар
Санхүүгийн тайлангийн аудит				
1	2012	Цэвэр агаар сангийн санхүүгийн тайлангийн аудит	2011	Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газар
2	2014	Цэвэр агаар сангийн санхүүгийн тайлангийн аудит	2013	
3	2015	Цэвэр агаар сангийн санхүүгийн тайлангийн аудит	2014	
4	2014	Улаанбаатарын цэвэр агаар төслийн санхүүгийн тайланд хийсэн аудит	2008-2010	
Гүйцэтгэлийн аудит				
5	2010	Төсвөөс утаа бага гаргах зориулалт бүхий түлш боловсруулахаар санхүүжүүлсэн хөрөнгийн зарцуулалт, үр дүн	2009-2010	Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газар
Нийцлийн аудит				
6	2013	Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааны хэрэгжилт	2011-2013	Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газар
7	2014	“ДЦС-2” ТӨХК-ийг түшиглэн 210 мянган тонн хагас коксжсон түлш үйлдвэрлэх хүчин чадалтай цогцолбор байгуулах төслийг хэрэгжүүлэх хөрөнгийн зарцуулалт, үр дүн	2010-2013	
Нийслэл дэх төрийн аудитын газраас хийгдсэн аудит				
8	2013	Нийслэлийн Агаарын чанарын албанаас Цэвэр агаар сан болон төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн ажлын хэрэгжилт	2011-2013	Нийслэл дэх төрийн аудитын газар
9	2018	Агаарын тухай хууль, түүнтэй холбогдох гарсан эрх зүйн актын хэрэгжилт	2015-2017	

4. Аудитын хамрах хүрээ

Цэвэр агаар сан болон 2008-2016 онд агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр гадаад, дотоодын хөрөнгөөр санхүүжигдсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэл, тайлагналтай холбоотой баримт материалд тулгуурлан Цэвэр агаар сан болон агаарын бохирдлыг бууруулах төрийн бодлогыг хариуцан хэрэгжүүлсэн байгууллагуудыг хамруулан шалгана.

Үндэсний аудитын газраас хийсэн гүйцэтгэлийн болон нийцлийн аудитаар өмнө нь хамруулан шалгасан төсвөөс утаа бага гаргах зориулалт бүхий түлш боловсруулахаар санхүүжүүлсэн хөрөнгийн 2009-2010 оны зарцуулалт, Цэвэр агаарын сангийн 2011-2013 үйл ажиллагаа, “ДЦС-2” ТӨХК-ийг түшиглэн 210 мянган тонн хагас коксжсон түлш үйлдвэрлэх хүчин чадалтай цогцолбор байгуулах төслийг хэрэгжүүлэх хөрөнгийн 2010-2013 оны зарцуулалт болон Нийслэл дэх төрийн аудитын газраас хийсэн Нийслэлийн Агаарын чанарын албанаас 2011-2013 онд гүйцэтгэсэн Цэвэр агаар сан болон төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн ажил, Агаарын тухай хууль, түүнтэй холбогдох гарсан эрх зүйн



актын 2015-2016 оны хэрэгжилтийг тус тус аудитын хамрах хүрээнээс хязгаарласан болно.

5. Эрсдэлийн үнэлгээ

Аудитын төлөвлөлтийн явцад Үндэсний архивын газар, Сангийн яам, Байгаль орчин аялал жуулчлалын яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны Байнгын хороо, Үндэсний аудитын газраас өмнөх жилүүдэд агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хийгдсэн аудитын тайлан зэрэг эх үүсвэрээс авч судалсан баримт материал, хийсэн урьдчилсан дүн шинжилгээ, харилцан ярилцлагад үндэслэн аудитын ерөнхий эрсдэлийг “Дунд” гэж үнэлэв. /дэлгэрэнгүйг хавсралт №1-д үзүүлэв/

6. Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журам болон гүйцэтгэлийн аудитын удирдамж /АДБОУС 3000-3100/-ийн дагуу Үндэсний архивын газар, шалгагдагч байгууллагууд, Олон улсын болон дотоодын судалгааны байгууллагуудаас аудитын зорилтуудад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлс, мэдээллийг авч, нөхцөл байдлын шинжилгээ хийх, үр дүнг шалгуур үзүүлэлттэй нь харьцуулан нягтлан шалгах, судалгаа хийх, зарим төсөл, арга хэмжээг түүвэрчлэн шалгаж дүгнэлт гарган зөвлөмж боловсруулна.

Аудитад мэргэжлийн зөвлөх ажиллуулах бөгөөд асуудлын шинжилгээний 1.1.1.1, 1.1.2.2, 1.2.2.2-т тусгасан асуудлыг шалгаж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулна. /дэлгэрэнгүйг хавсралт №4-т үзүүлэв/

7. Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд

- Монгол Улсын Үндсэн хууль
- Төсвийн тухай хууль
- Төсвийн удирдлага санхүүжилтийн тухай хууль /хүчингүй болсон/
- Агаарын тухай хууль
- Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хууль
- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль
- Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль
- Зөрчлийн тухай хууль
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Ариун цэврийн тухай хууль
- УИХ-ын 2008.11.21-ний өдрийн 35 дугаар тогтоол “Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай”
- УИХ-ын 2012.09.18-ны өдрийн 37 дугаар тогтоол “Монгол улсын засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай”
- УИХ-ын 2010.06.25-ны өдрийн 36 дугаар тогтоол “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөр батлах тухай”
- УИХ-ын 2008.01.31-ний өдрийн 12 дугаар тогтоол “Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого батлах тухай”
- УИХ-ын 2013.02.08-ны өдрийн 23 дугаар тогтоол “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг батлах тухай”
- УИХ-ын 2016.02.05-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 батлах тухай”
- Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2008-2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэл

- УИХ-ын 2010.07.15-ны өдрийн 48 дугаар тогтоол “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, зөвлөмж
- УИХ-ын 2011.02.10-ны өдрийн 11 дүгээр тогтоол “Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай”
- УИХ-ын 2005.06.09-ний өдрийн 32 дугаар тогтоол “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөр”
- УИХ-ын 2007.06.28-ны өдрийн 46 дугаар тогтоол “Агаарын бохирдлыг бууруулах зарим арга хэмжээний тухай”
- УИХ-ын 1997.12.26-ны өдрийн 106 дугаар тогтоол “Төрөөс экологийн талаар баримтлах бодлого”
- УИХ-ын 2005.01.13-ны өдрийн 03 дугаар тогтоол “Байгаль орчны талаар төрөөс баримтлах бодлого”
- УИХ-ын 2001.11.08-ны өдрийн 81 дүгээр тогтоол “Нийгмийн эрүүл мэндийн талаар баримтлах бодлого”
- УИХ-ын 2011.01.06-ны өдрийн 02 дугаар тогтоол “Уур амьсгалын өөрчлөлт үндэсний хөтөлбөр”
- УИХ-ын 2010.12.09-ний өдрийн 72 дугаар тогтоол “Түлш, эрчим хүчний салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2017.03.20-ны өдрийн 98 дугаар тогтоол “Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр”
- УИХ-ын 1998.04.09-ний өдрийн 29 дүгээр тогтоол “Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр”
- Засгийн газрын 1999.05.25-ны өдрийн 82 дугаар тогтоол “Агаарыг хамгаалах хөтөлбөр”
- Засгийн газрын 1995.08.25-ны өдрийн 151 дүгээр тогтоол “Байгаль орчны хуулиудыг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2000.10.23-ны өдрийн 161 дүгээр тогтоол “Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг батлах тухай”
- Засгийн газрын 2001.03.28-ны өдрийн 70 дугаар тогтоол “Утаа багатай түлш, хэмнэлттэй зуухны үйлдвэрлэлийг дэмжих тухай”
- Засгийн газрын 2002.09.09-ний өдрийн 182 дугаар тогтоол “Хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай”
- Засгийн газрын 2002.07.04-ний өдрийн 140 дүгээр тогтоол “Эрчим хүчний тогтвортой хөгжлийн стратеги төлөвлөгөө батлах тухай”
- Засгийн газрын 2005.12.14-ний өдрийн 245 дугаар тогтоол “Орчны эрүүл мэнд Үндэсний хөтөлбөр”
- Засгийн газрын 2007.03.20-ны өдрийн 70 дугаар тогтоол “Нийслэлийн талаар авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2008.01.16-ны өдрийн 14 дүгээр тогтоол “Агаарын бохирдлыг бууруулах талаар ойрын хугацаанд авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2010.10.23-ны өдрийн 273 дугаар тогтоол “Агаарын төлбөрийн хэмжээ тогтоох тухай”
- Засгийн газрын 2011 оны 359 дүгээр тогтоол “Эрүүл хот, дүүрэг, сум, баг, ажлын байр, сургууль Үндэсний хөтөлбөр”
- Засгийн газрын 2011.11.02-ны өдрийн 309 дүгээр тогтоол “Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын айл өрхөд цахилгаан эрчим хүчний үнийн урамшуулал олгох журам”
- Засгийн газрын 2012 оны өдрийн 227 дугаар тогтоол “Агаарын бохирдлын бүрэн төлбөрөөс чөлөөлөх ААН, Байгууллагын жагсаалт”
- Засгийн газрын 2013.01.19-ний өдрийн 18 дугаар тогтоол “Агаарын бохирдлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2016.12.28 “Гэр хорооллын айл өрхийн шөнийн тарифыг тэглэх тухай”
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2011 оны 43 дугаар зарлиг, 2012 оны 71 дүгээр зарлиг “Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороог байгуулах, түүний бүрэлдэхүүн, ажиллах журам батлах”
- Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн тогтоолууд

- Нийслэлийн Засаг даргын захирамж
- Монгол Улсын холбогдох стандартууд
- Засгийн газрын 2010.10.23-ны өдрийн 273 дугаар тогтоол “Цэвэр агаар сангийн үйл ажиллагааг зохицуулах олон талын оролцоог хангах орон тооны бус Удирдах зөвлөлийн ажиллах журам”
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2011 оны 43 дугаар зарлиг, 2012 оны 71 дүгээр зарлиг “Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороог байгуулах, түүний бүрэлдэхүүн, ажиллах журам”
- Байгаль, орчин аялал жуулчлалын сайдын 2011.06.15-ны өдрийн А-200 дугаар тушаал “Цэвэр агаар сангийн стратеги, бүтэц, зохион байгуулалтын хөтөлбөр”
- Цэвэр агаар санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах журам
- Сангийн сайдын 2007 оны 81 дүгээр тушаал “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагааг зохицуулах журам”
- Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоол “Босго үнэ батлах тухай”
- “Босго үнэ батлах тухай” Засгийн газрын 2006 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 22 дугаар тогтоол, “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2007 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн 42 дугаар тогтоол
- Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны тогтоолууд
- Холбогдох бусад хууль, журам, тогтоол, шийдвэр

8. Аудит хийх багийн бүрэлдэхүүн

Аудитыг Гүйцэтгэлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор М.Давааням удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер З.Ариунзаяа хэрэгжүүлж, ахлах аудитор Д.Гандолгор, аудитор Э.Уянга, М.Гүнжмаа, Б.Булган, Н.Эрдэнэбаяр, аудитын зөвлөх, гэрээт ажилтан Ш.Наранбаатар нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэнэ.

9. Аудит хийх хугацаа

Аудитын төлөвлөлтийн шатны ажлыг 2018 оны 4 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлүүлж, аудитын тайлангийн төслийг 06 дугаар сарын 22-ны өдрийн дотор боловсруулан, үе шатны хяналтаар оруулж, 2018 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Монгол Улсын Их Хуралд хүргүүлнэ.

10. Аудитын хөтөлбөр

Аудитын хөтөлбөрийг энэхүү төлөвлөгөөний хавсралт №4-т үзүүлэв.

11. Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам

Аудитын тайлан нь оршил хэсэг, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж, холбогдох байгууллагын санал гэсэн хэсгүүдээс бүрдэх бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг аудитын зорилт тус бүрээр гаргана.

Аудитын тайлангийн төслийг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн зөвшөөрлөөр холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулан санал авч, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын зөвлөлийн болон Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн баталгаажуулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.